



## НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 2/56

Улаанбаатар хот

Г Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг шторк хийх тухай Г

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6, 30 дугаар зүйлийн 30.1.16, 30.2, 30.3, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын Онцгой комиссын 2019 оны 01, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2019 оны 02, Нийслэлийн Онцгой комиссын 2019 оны 02 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэх, сургалт сурталчилгааг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх мэдээлэл сурталчилгааг иргэдэд хүртээмжтэй хүргэх зорилгоор 30 секундын үргэлжлэх хугацаатай ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг шторкыг мэргэжлийн байгууллагаар хийлгэсүгэй.

2. Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг шторк хийхэд шаардлагатай зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг шторк хийхэд шаардагдах 2.750.000 (Хоёр сая долоон зуун тавин мянган) төгрөгийг зохих зардлаас гаргахыг Санхүү, эдийн засгийн хэлтэс (дэд хурандаа Д.Урантулга)-т зөвшөөрсүгэй.


4. Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг шторкыг хариуцан хийлгэхийг Гамшгаас урьдчилан сэргийлэх хэлтэс (хурандаа Г.Нэргүй)-т даалгасугай.

5. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Гал түймэртэй тэмцэх, гамшгаас урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан Тэргүүн дэд дарга, дэд хурандаа Н.Нямхорлоод даалгасугай.

ДАРГА,  
ХУРАНДАА  Ж.ЧУЛТЭМСҮРЭН



Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын  
2019 оны 06 дугаар сарын .... ны өдрийн  
..... тушаалын хавсралт



ОЙ, ХЭЭРИЙН ТҮЙМРЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ  
СЭРЭМЖЛҮҮЛЭГ ШТОРК ХИЙХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

д/ д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Нэгжийн үнэ /төгрөг/	Тоо хэмжээ	Нийт /төгрөг/	Хянасан
1	Зураг авалт хийх	минут	70.000	30	2.100.000	
2	Эвлүүлэг хийх ажлын хөлс	цаг	55.000	10	550.000	
3	Бусад зардал				100.000	
Нийт					2.750.000	

--ооо--